



“ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ”  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

**ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН БАГАЖ ХЭРЭГСЭЛ  
НИЙЛҮҮЛЭХ НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ  
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Тендерийн нэр: “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн багаж  
хэрэгсэл нийлүүлэх”

Тендерийн дугаар: **ЦДУС/202001157**

**УЛААНБААТАР ХОТ  
2020 оны 03 дугаар сарын 30-ны өдөр**

## ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2020-03-30

“Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ” ТӨХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “**Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн баагаж хэрэгсэл нийлүүлэх**” тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх техникийн тодорхойлолт, тоо ширхэг болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 30,000 /гучин мянга/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендерийг 2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 10:00 цагаас өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг Улаанбаатар хот-36 Хан-Уул дүүрэг 3 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө-45 “ЦДҮС” ТӨХК-ний байр 3 дугаар давхар 309 тоотод 2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 10:10 цагт тендерийг нээнэ.

**Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 3 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө-45, “ЦДҮС” ТӨХК-ийн төв байр, 3 дугаар давхар 309 тоот.**

**Худалдан авах ажиллагаа, Ханган нийлүүлэлтийн хэлтэс.  
Утас: 99248880. Факс:976-70043287**

## Нэг. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**
  - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
  - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
  - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
  - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
    - (а) Үнийн санал;
    - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
    - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
    - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
    - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тендерийн үнэ**
  - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
  - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
  - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсэн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
  - 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдэж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
- 5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
  - 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 6. Алдааг залруулах**
  - 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
    - (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэндэйг зөв гэж үзнэ;

- (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
- (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үргүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.



**Хоёр ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТОӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТОӨЗ 1.1	<ul style="list-style-type: none"> <li>- Сүүлийн 1 жилийн санхүүгийн тайлан /аудитын дүгнэлтийн хамт/;</li> <li>- Сүүлийн 1 жилийн туршилагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн актын хамт/;</li> <li>- Улсын бүртгэлийн гэрчилгээ;/нотариатаар баталгаажуулна/</li> <li>- Шүүхийн тодорхойлолт;</li> <li>- Татварын тодорхойлолт /Цахим/;</li> <li>- Сонгосон бараа материал, багаж хэрэгслийн техникийн тодорхойлолт, дэлгэрэнгүй танилуулга, зураг ирүүлнэ.</li> <li>- Компанийн дэлгэрэнгүй танилцаалга;</li> </ul> <p>Жич: Дээрх баримт бичгийн аль нэгийг ирүүлээгүй нь тендерээс татгалзах үндэслэл болно.</p>
ТОӨЗ 2.1	<p><b>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</b></p> <p>Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Цахим худалдан авах ажиллагааны систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> -д өөрийн аж ахуйн нэгжийн хувийн нууцлалын кодоор нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ.</p> <p>Огноо: <b>2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр</b></p> <p>Цаг: <b>10 цаг 00 минут.</b></p>
ТОӨЗ 2.1	<p><b>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</b></p> <p>Байгууллагын хаяг: <b>Улаанбаатар хот-21013, Хан-Уул дуурэг 3 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө-45, “ЦДУС” ТӨХК-ийн төв байр.</b></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <b>3-н давхар, 309 тоот</b></p> <p>Огноо: <b>2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр нээлт хийнэ.</b></p> <p>Цаг: <b>10 цаг 10 минут</b></p>
ТОӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн багаж хэрэгсэл нийлүүлэх”</b></p> <p><b>ЦДУС/202001157</b></p>
Бусад:	Хөнгөлөлт урамшуулалт үзүүлэх бол албан бичгээр ирүүлнэ.

**Гурав. БАРААНЫ ЖАГСААЛТ БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ**

Нэр	Тодорх оил bolt	Тоо ширхэ г	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Хөндийрүүлэх штанг 10кВ	ХАБЭА-ын хамгаалах хэрэгсэл, ажлын багажинд тавьдах шаардлага	3	Ш	“ЦДУС” ТӨХК- ийн төв байр	21 хоног	35 хоног	
Хөндийрүүлэх штанг 110кВ		5	Ш				
Зөөврийн газардуулга 110кВ		3	Ш				
Зөөврийн газардуулга 35кВ		3	Ш				
Зөөврийн газардуулга 6кВ		1	Ш				
Хүчдэл заагуур УВН 90		20	Ш				
Хүчдэл заагуур УВН 80		18	Ш				
Хөндийрүүлэх резин бээлий		42	Ш				
Боть		8	хос				
Нүдний хамгаалах шил		259	Ш				
Ажилд оруулагчийн цоож /ногоон өнгө/		74	Ш				
Ажил гүйцэтгэгчийн цоож /улаан өнгө/		74	Ш				
Олон нүхтэй цүүн түгжээ		74	Ш				
Олон үйлдлийн кабель түгжээ		31	Ш				
Цоож хадгалах тунгалаг нүүртэй хайрцаг		8	Ш				
Цоож хадгалах төмөр сав		8	Ш				
Хүчдэл заагч 10 кВ		8	Ш				
Хүчдэл заагч 35 кВ		6	Ш				
Хүчдэл заагч 110 кВ		2	Ш				
Хүчдэл заагч 220 кВ		1	Ш				

Гурав. **ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

**ХАБЭА-ЫН ХАМГААЛАХ ХЭРЭГЛЭЛ, АЖЛЫН  
БАГАЖИНД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

1. Боть болон резинэн бээлий нь ажлын гутал, ажлын бээлийтэй давхар өмсөж хэрэглэх боломжтой, тохирсон хэмжээний том размертай байна.
2. Резинэн бээлий, боть нь зориулалтын хөндийрүүлэх материалыаар хийгдсэн байх бөгөөд үйлдвэрийн туршилт, баталгаажуулалт хийгдсэн байх
3. Резинэн бээлий, боть нь будагүй тусгай тэмдэглэлгүй байх бөгөөд 1000В-оос дээш хүчдэлийн түвшинд хэрэглэгдэх боломжтой байна.
4. Мэргэжлийн байгууллагаас зөвшөөрөгдсөн үйлдвэрийн туршилт, баталгаажуулалт хийгдсэн байх.
5. 1000В-оос дээш хүчдэлтэй цахилгаан төхөөрөмжид зориулсан хамгаалах хэрэгслийн хөндийрүүлэгч хэсэг нь бариул талаасаа хөндийрүүлэлтийн материалыаар хийсэн хязгаарлагч цагираг буюу тулгууртай байх
6. Голоороо хөндий хөндийрүүлэгч хэрэгслийн дотор тоос чийг оруулахгүйн тулд үзүүрүүдийг бөглөөгөөр тагласан байх
7. Багаж хэрэгсэл нь шаардлагатай үйлдвэрийн баталгаажилт, туршилт хийгдсэн байх
1. Зөөврийн газардуулгын урт нь фаз хоорондын хийц хэсэг кабелийн урт нь 35/110/220 кВ-ын хүчдэлийн түвшин бүрт тохирсон хэмжээтэй байх
2. Зөөврийн газардуулгын дамжуулагч хэсэгт холбогдох хэсэг нь дамжуулагч болох бөгөөд бат бөх, эдэлгээ даах чанартай байх
3. Дамжуулагч хэсэг, газардуулах хэсэгт холбогдох хийц хэсэг нь тухайн хүчдэлийн түвшин дамжуулах утасны диаметрт тохирсон байх бөгөөд бат бөх, холбох үйлдэл хийхэд хялбар байх
4. Газардуулагч утасны хөндлөн отглолын талбай нь механик бөх батын нөхцөлөөс шалтгаалж  $16\text{mm}^2$  -аас багагүй байх
5. Хүчдэл заагуур нь хийц хэсэг хөнгөн, хүчдэл мэдрэх үед гэрэл асах мөн сингал өгч дуу гардаг байх,
6. Хүчдэл заагуур нь мэдрэх хүчдэлийн түвшинг тохируулж болдог байж болох бөгөөд үйлдвэрийн туршилт баталгаажиллат хийгдсэн байна.
7. Цоож нь аюулгүй ажиллагааг хангах зориулалт бүхий өнгөөр ялгасан хүчдэлтэй нөхцөлд ашиглагдах тул хөндийрүүлэгч гадаргуутай байна.

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

## 1. ҮННИЙ САНАЛЫН МАЯГТ

[огноо]

**Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Б.Нямсамбуу танаа**

- Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
- Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## **2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ**

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.


Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

<b>1. Шалгах болон турших</b>	1.1.	Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
<b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт</b>	2.1.	Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
<b>3. Оюуны өмчийн эрх</b>	3.1.	Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
<b>4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх</b>	4.1.	Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
<b>5. Баталгаат засварын хугацаа</b>	5.1.	Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <b>1 жил</b> байна.
<b>6. Гэрээнд өөрчлөлт оруулах</b>	6.1.	Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
<b>7. Төлбөр</b>	7.1.	Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш хоногийн дотор шуурхай хийнэ.
<b>8. Бараа нийлүүлэх хуваарь</b>	8.1.	Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
<b>9. Алданги оногдуулах</b>	9.1.	Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
<b>10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах</b>	10.1.	Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.

**11. Маргааныг  
шийдвэрлэх**

11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.



## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- |   |  |
|---|--|
| <p><b>1. Шалгах болон турших (ГЕН – 1)</b></p>  | <p>1.1. Нийлүүлэгч нь бараа материалд шаардлагатай шалгалт туршилтуудыг хийлгэнэ. Мөн чанар стандартын найдвартай байдлыг хариуцна. Захиалагч талаас холбогдох хэлтсийн инженер техникийн ажилчидар шалгуулж, хүлээн авна.</p>   |
| <p><b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)</b></p>  | <p>2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:</p> <ul style="list-style-type: none"><li>1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;</li><li>2) барааг хүргэсэн тухай баримт, тэмэр замын болон тээврийн баримт;</li><li>3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;</li><li>4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;</li><li>5) барааны гарал үүслийн гэрчилгээ.</li></ul> |
| <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> |  |
| <p><b>3. Баталгаат засвар (ГЕН-5)</b></p>   | <p>5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.</p> <p>Чанарын баталгаат хугацаа 12 сар байна. Баталгаат хугацаанд гарсан гэмтлийг нийлүүлэгч тал бүрэн хариуцна. Батлгаат хугацааны барьцаа хөрөнгө гэрээний нийт үнийн дүнгийн 5% байх бөгөөд бараа материал хүлээн авч гэрээ дүгнэсэн өдрөөс хойш 06 сарын дараа 5%-ийг олгоно.</p>  |
| <p><b>4. Төлбөр (ГЕН – 7)</b></p>   | <p>7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:</p> <p>Гэрээний үнийн дүнгийн <b>95</b> хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.</p>  |
| <p>Урьдчилгаа төлбөр олгохгүй.</p>  |  |
| <p><b>5. Алданги оногдуулах (ГЕН - 9)</b></p>   | <p>9.1. Алданги оногдуулах хувь: Гэрээний нийт үнийн дүнгийн <b>0.05%</b> байна.</p> <p>Алдангийн нийт дүн: Гэрээний нийт үнийн дүнгийн <b>5%-иас</b> хэтрэхгүй.</p>   |

## Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ<sup>1</sup>

БАТЛАВ.

### ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)  
(Гарын үсэг)  
(Албан тушаал)

### НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)  
(Гарын үсэг)  
(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [нийлүүлэгчийн нэр] (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож  
\_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ сарын \_\_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

- Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
- Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “бараа” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
- Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
- Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-наас \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
- Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>2</sup>;  
Үнийн санал;

Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]